

Сар бүр гаргадаг “Найдваргай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Хойд, Төв, Өмнөд Америкийн эмэгтэйчүүдийн төлөөх залбирал 1

Латин Америк, Карибын тэнгисийн орнууд нь соёлын болон оюун санааны баялаг их өвийг эзэмшдэг. Бусад бүс нутгийн нэгэн адил эдгээр бүс нутагт олон эмэгтэйчүүдийн амьдрал зовлон зүдгүүр, итгэл найдваргүй байдалтай холбоотой байдаг. Латин Америк болон Карибын тэнгисийн орнуудын Найдвар доторх эмэгтэйчүүд бүлгийн сургалт, радио нэвтрүүлэг, залбирлаар дамжуулан эмэгтэйчүүдэд итгэлээр өсөхөд нь туслах сүнслэг нөөц өр хангадаг бөгөөд бүс нутаг бүрт үйчлэлүүдийг идэвхтэй явуулж байна.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Эзэн минь, Ариун Сүнсээрээ дамжуулан бүх дэлхийн сүм чуулгануудад эв нэгдлийг авчраач хэмээн залбирч байна. Бид бусдыг өөрөөсөө дээр хэмээн үзэж, бие биеэ хайрлах зүрх сэтгэлээр биднийг өөрчлөөч. (Еф. 4:2-3)
2. Эзэн минь, Бүгд Найрамдах Доминиканы эмэгтэйчүүдэд сайн мэдээг ажил, сургуульдаа болон гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хөршүүддээ тунхаглах эр зоригийг өгөөч хэмээн залбирч байна. (1 Петр. 3:15-16)
3. Аав аа, Бразилийн томоохон хотуудад хүчирхийлэлд өртөж нас барсан болон сураггүй алга болсон хүүхдүүдийн ээжүүдийн сэтгэлийг Та тайвшруулаач хэмээн залбирч байна. (Илч. 21:4)
4. Эзэн минь, Парагвайн шоронгоос суллагдсан эмэгтэйчүүдийг нийгэмд зөв зохистойгоор эргүүлэн авчирч, гэмт хэргийн амьдралд эргэн орохгүй байхад нь туслаач. (Гал. 6:1)

5. Б у р х а н минь, Уругвайн залуу эмэгтэйчүүд бэлгийн харилцааны хувьд цэвэр ариун байж, эр нөхөртөө очих хүртлээ библийн зарчмуудыг хүлээн зөвшөөрөхийн төлөө залбирч байна. (1 Кор. 6:18)
6. Эзэн минь, бид Бонайрын засгийн газрын удирдагчдын төлөө залбирч байна. Тэдэнд арлынхаа талаар шийдвэр гаргах, мөн ажил, гэр хоёрын хооронд цагийг тэнцвэржүүлэх мэргэн ухаан өгөөч. (1 Тим. 2:1-2)
7. Аав аа, АНУ-ын залуу эмэгтэйчүүдийн оюун ухаан, сэтгэл хөдлөлийг эдгээгээч хэмээн бид залбирч байна. Тэд Танаас өөрийн мөн чанар, үнэний эх сурвалж, амьдралын утга учрыг олох болтугай. (Флп. 4:6-7)
8. Сар бүр залбирлын хуанли ашиглан дэлхий даяарх эмэгтэйчүүдийн төлөө үнэнчээр дэмждэг Канадын үйлчлэлийг дэмжигчдийнхээ төлөө Бурхан минь, Таныг бид магтъя. (Иаков 5:16б)
9. Аав аа, Бүгд Найрамдах Доминиканы эмэгтэйчүүдэд сүнслэгээр төлөвшихөд нь Та туслаач, ингэснээр тэд нийгмийн дарамтнаас үл шалтгаалан Таныг үнэнчээр дагахаас саад болохгүй байх болтугай. (Евр. 5:14)
10. Эзэн минь ээ, бид биеэ үнэлж буй Бразил эмэгтэйчүүдийг чөлөөлж, аврахын төлөө залбирч байна. Тэд Танаас эдгэрэлт, жинхэнэ эрх чөлөөг олох болтугай. (Иохан 8:36)
11. Бурхан минь, Парагвайд өсөж буй эмэгтэйчүүдийн амь насыг хөнөөх байдлыг зогсоогооч хэмээн бид залбирч байна. Сүм чуулган болон засгийн газарт эдгээр эмэгтэйчүүдэд туслахад шаардлагатай зөв арга хэмжээг авахад туслаач. (Дуу. 138:7)
12. Уругвай дахь радиогоор дамжуулан залбирлын хуанлиг бичих боломж олгосон Танд бид талархаж байна. Эзэн минь биднийг сонсож байхдаа залбирдаг эмэгтэйчүүдийн төлөө талархаж байна. (Еф. 1:16)
13. Тэнгэрлэг Аав минь, Бонайрт хар тамхичидтай ажилладаг хүмүүст тэвчээр, мэргэн ухааныг өгөөч. Эдгээр донтолтын үндэс устаж, урт хугацааны шийдэлд хүрэх болтугай. (1 Кор. 10:13)
14. А а в аа, АНУ-д байгаа эмэгтэйчүүдэд өдөр бүр таны зүрх сэтгэлийг эрэлхийлэхийн тулд завгүй амьдралдаа цаг гаргахад нь тусал. Таныг гэсэн тэдний хайр бүхнээс дээгүүр байх болтугай. (Лам. 3:25)

15. Эзэн минь, Канадын Христэд итгэгчдэд сайн мэдээг хэрхэн соёлоор дамжуулан хуваалцахыг мэдэхэд нь туслах Канад TWR санаачилгыг Та ерөөж, удирдан чиглүүлэх болтугай. (Үйлс 1:8)
16. Бурхан минь, Доминиканы Бүгд Найрамдах Улс дахь ядарсан ээжүүдийг Та хүчирхэгжүүлээч. Тэд өөрсдийн хэрэгцээг хангахын тулд ажиллаж байхдаа Тантай уулзаж, Таныг сонсох болтугай. (Ис. 40:29)
17. Эзэн минь, та харийн хүнийг битгий гадуурхаарай гэж хэлдэг. Бразилд дүрвэгсэд байгаа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг хамгаалж, дэмжих хууль бий болох болтугай хэмээн залбирч байна. (Египетээс гарсан. 22:21)
18. Бурхан минь, Парагвайн эмэгтэйчүүдэд оюун ухаан, ялгах чадварыг өгөөч, ингэснээр тэд сэтгэл санааны болон бие махбодийн хүчирхийлэлд өртөхгүй байх болно. (Иаков 1:5)
19. Эзэн минь, Уругвайд амиа хорлохоор зэхэж буй өсвөр насны охидод амьдралын үнэ цэнэ, зорилгоо ойлгоход нь туслаач. Тэдний нэр төр, мөн үнэ цэнийг сэргээж, тэд Тантай хамт ирээдүйгээ төлөвлөх болтугай хэмээн залбирч байна. (Иер. 29:11)
20. Эзэн Бурхан минь, Карибын тэнгист байгаа хүмүүс амьдралаа Христэд зориулж, Түүний сургаалыг дуулгавартай дагаснаар тэдэнд ирээдүйтэй ирээдүй байх болтугай хэмээн залбирч байна. (Сур. 16:3)
21. Бурхан минь, Бүгд Найрамдах Доминикан улсад зөвхөн гэртээ суудаг эмэгтэйчүүд гэр бүлдээ үйлчлэхийн ач тус, ерөөлийг ойлгох болтугай. (Сур. 11:25)
22. Аав аа, Бразил дахь TWR-ийн Найдвар доторх эмэгтэйчүүд багт үйлчлэлд хэрэгтэй, үр дүнтэй контент бүтээх мэргэн ухаан, бүтээлч байдал, урам зоригийг өгөх болтугай. (Сур. 2:6)
23. Эзэн минь, Парагвайд хүүхдүүдээ хаягдсан, зарим нь бүр гудамжинд амьдардаг өндөр настай эмээ нарыг Та хамгаалаач. Хүүхдүүдийнхээ зүрх сэтгэлд хүрч, тэд эцэг эхээ хүндэлж, халамжлах болтугай. (1 Тим. 5:3–5)
24. Уругвайд жендэрт суурилсан хүчирхийлэл өргөн тархсан. Бурхан минь, эхнэр хүүхдээ хорлодог харгис хэрцгий эрчүүдийн зүрх сэтгэлд Та хүрээч. Тэд Христээр ирэх авралыг олж, гэр бүлээ хайрлаж сурах болтугай. (Мат. 19:25–26)
25. Аав аа, Карибын тэнгис дэх ганц бие эцэг эхтэй гэр бүлүүдийг хамгаалаач гэж бид Танаас гуйж байна. Эцэг эхчүүдэд хүүхдээ хэрхэн хайрлаж, анхаарч, халамжлах талаар Өөрийн үгээ Та тэдэнд өгөөч. (1 Тим. 5:8)
26. Бурхан минь, Бүгд Найрамдах Доминиканы эмэгтэйчүүд Танаас өгөгдсөн бэлэг, авьяасаараа Таныг алдаршуулан бусдад Таныг таньж, мэдүүлэхэд нь туслаач. (Ром. 12:6–8)

27. Эзэн минь, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай өвчтөнүүдийн тоо нэмэгдэж буй Парагвай дахь эмэгтэй эмнэлгийн ажилтнуудад мэргэн ухаан, ухаалаг байдлыг өгөх болтугай. (Дуу. 34:17–18)
28. Аав аа, та өөрийнхөө дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хоёуланг нь бүтээсэн. Бразил эмэгтэйчүүдийг ажлын байран дээр адил тэгш үнэлж, үнэлдэг байхын тулд хүмүүсийн зүрх сэтгэл, оюун ухааныг Та өөрчлөөч. (Сур. 31:16–17)
29. Их Эзэн минь, Уругвай дахь Христэд итгэгч эмэгтэйчүүд итгэл үнэмшилдээ бат зогсож, сайн мэдээг бусадтай хуваалцах үүрэг хариуцлагаа хүлээх авах болтугай. (Ром. 1:16)
30. Бурхан аав аа, Бонайр дахь хүний наймаа хийдэг хүмүүсийг Та илчлээч. Хүний наймааны хохирогч болсон эмэгтэйчүүд зүүрх сэтгэлийн эдгэрэлийг олох болтугай. (Дуу.82:3-4)
31. Эзэн минь, Парагвайн олон нийт, нийгмийн байгууллагууд хувийн, сэтгэл санааны болон гэр бүлийн хямралтай тулгарч буй эмэгтэйчүүдэд энэрэнгүй тусламж үзүүлэх болтугай. (Ром. 12:13)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. 2024 онд болох УИХ-н сонгууль шударга болж, Бурха наас эмээдэг, шударга хүмүүс гарч ирж улс орноо зөв удирдаж, улс орноо хямралаас гаргахын төлөө.
2. Монгол улсын хууль тогтоомж шударгаар үйлчилж, Монгол улс эдийн засгийн хямралаас гарахын төлөө.
3. Хиймэл шүтээн шүтэж харанхуй дотор алхаж байгаа хүмүүс Бурханыг таньж мэдэн гэм нүгэлээсээ эргэж гэмшихийн төлөө
4. Монголын гэр бүлүүд Эзэнтэй хамт алхдаг байхын төлөө. Гэр бүлүүд дотор өсөж торниж байгаа хүүхдүүдэд эцэг эхийн нөлөө зөв байхын төлөө
5. Монгол эрчүүд архинд донтон, гэр бүлдээ үл хүндүүлэх байдал их байна. Монгол эрчүүдийг Эзэн өөрчлөн, гэр бүлийнхээ тэргүүн, гэр бүлдээ хайрлагдсан байхын төлөө залбирч байна.
6. Монголын залуу гэр бүлүүдийн дунд салалт их байгаа тул залуучууд зөв сонголт хийн, үр хүүхдээ өнчрүүлж үлдээхгүй байхын төлөө
7. Монгол чуулганууд сэргээгдэж, сайн мэдээ орон даяар тунхаглагдаж, улс орноороо Эзэн рүү хандан залбирдаг, Эзэнээс эмээдэг ард түмэн болохын төлөө залбирцгаая.

Хувьанна

국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.